



АЛТАЙ ХОТХОН НАРНЫ ХОРООЛЛЫН ДУНДАХ ТӨВ АВТО ЗАМ ДЭЭГҮҮРХ ЯВГАН
ХҮНИЙ ГҮҮРЭН ГАРЦЫН ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ, ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖЛЫН
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024 оны 06 дугаар сарын //...

№ 4/153

Улаанбаатар хот

1.Үндэслэл	Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 32 дугаар тогтоол Баянгол дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/141 дүгээр захирамж
2.Ажлын цар хүрээ	-Баянгол дүүргийн 24-р хороо, явган зорчигчийн гүүрэн байгууламжийн орчим цахилгаан дамжуулах 10 кВ кабель шугам, 0.4 кВ кабель шугам шилжүүлэх ажил - Гэрэлтүүлгийн ажил - Гүүрэн байгууламжийн авто замын зорчих хэсэгт өндрийн буюу оврын хязгаарлалт угсрах /лазер мэдрэгчтэй гэрэл дохиололтой/
3. Захиалагч байгууллага	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар
4. Төсөл гүйцэтгэх хугацаа	Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
5. Төсөл боловсруулах байгууллага	Холбогдох тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий байгууллага
6.Барилгын ажлын зохион байгуулалт	1. Цахилгаан дамжуулах кабелийн шугам шилжүүлэх, гэрэлтүүлэг, оврын хязгаарлалт хийх ажлыг зохион байгуулахдаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх арга хэмжээ авч хөдөлмөр хамгаалал аюулгүй байдал /түр зам, хаалт, тэмдэг тэмдэглэгээ гэх мэт/-ийг бүрэн хангаж ажиллана. 2. Гүйцэтгэгч байгууллага: Холбогдох газраас батлагдсан цахилгаан дамжуулах кабелийн шугам шилжүүлэх, гэрэлтүүлэг, оврын хязгаарлалт угсрах ажилд шаардлагатай засвар шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэх хугацаанд аюулгүй байдал, стандарт, норм дүрмийг чанд мөрдөж ажиллана. Гүйцэтгэгч 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайлбар болон тоо хэмжээг гарын авлагад заагдсан зааврын дагуу фото зургаар баримтжуулан холбогдох албан тушаалтнаар баталгаажуулж захиалагч талд албан бичгээр хүргүүлнэ. Зааврын дагуу фото зургаар баримтжуулаагүй, 7 хоног тутамд хийгдсэн ажлын тайланд тусгагдаагүй ажилбар бүрийг гүйцэтгэлээс хасч тооцно. Зурган баримтжуулалтад зориулалтын метр, рейк, гадас, самбар зэргийг ашиглана. Нөгөө талаас

	<p>холбогдох БНБД-үүд техник технологийн стандартуудад заасан шаардлагыг хангаж ажиллахыг анхаарна уу.</p> <p>3. Цахилгаан дамжуулах кабелийн шугам шилжүүлэх, гэрэлтүүлэг, оврын хязгаарлалт хийх ажлыг хариуцан ажиллах инженер, техникийн ажилчид нь уг ажлыг эхлэхээс ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд энэ төслөөс өөр бусад төсөлд давхар ажиллахгүй болохыг анхаарч, хүн хүч, машин механизмын хуваарилалтын графикийг батлуулж ажиллана.</p> <p>4. Гүйцэтгэгч байгууллагын товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж буй ажил үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх дуусах хугацааг мэдээллийн самбарт үзүүлж олон нийтэд үзэгдэхүйц газар байршуулна. Ажлыг батлагдсан төлөвлөгөө аргачлалын дагуу гүйцэтгэнэ. Ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд шаардагдах хүн хүчний графикийг хамтатган батлуулна.</p>
7. Бусад	<p>Цахилгаан дамжуулах кабелийн шугам шилжүүлэх, гэрэлтүүлэг, оврын хязгаарлалт хийх ажил дууссан өдрөөс хойш 21 хоногийн дотор гүйцэтгэлийн баримт бичгийг захиалагчид цаасаар болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө.</p> <p>Ажлын үе шат бүрийн далдлагдсан ажил бүр дээр акт бичиж инженерээр баталгаажуулна.</p> <p>Тухайн ажлыг эхлэн баривулсан инженер техникийн ажилтан тус ажлыг бүрэн дуусгаж, баримт бичгийг бүрдүүлэн ажил хүлээлцэх комисс ажиллуулж, ашиглалтад хүлээлгэж өгнө.</p>

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ
АХУЙН ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

Д. Мөнх-Эрдэнэ Г.МӨНХ-ЭРДЭНЭ

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Г.Энхцэнгэл Г.ЭНХЦЭНГЭЛ

БОЛОВСРУУЛСАН
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ
АХУЙН ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

Г.Нямсүрэн Г.НЯМСҮРЭН